



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/412


Улаанбаатар хот

Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээч сонгон шалгаруулах, ажиллуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18, 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээч сонгон шалгаруулах, ажиллуулах журам”-ыг нэгдүгээр, “Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (А.Өнөржаргал), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа), аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/118, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 363 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн орон тооны бус шинжээч (цаашид шинжээч гэх) сонгон шалгаруулах, томилон ажиллуулах, чөлөөлөхтэй холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, технологи, гүйцэтгэлд хөндлөнгийн, хараат бус үнэлгээ хийж, дүгнэлт гаргахаар томилогдсон мэргэжилтнийг эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээч гэнэ.

1.3. Шинжээч нь хүнлэг энэрэнгүй, хүн бүрт тэгш, хүндэтгэлтэй хандах, үл ялгаварлах, чин үнэнч, шударга, хариуцлагатай байх, байнга суралцаж, хөгжих гэсэн ёс зүйн тулгуур зарчмыг баримтлан ажиллана.

1.4. Магадлан итгэмжлэлийн шинжээч ажиллуулахтай холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн асуудал хариуцсан нэгж (цаашид ажлын алба гэх) удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Хоёр. Шинжээч сонгон шалгаруулах

2.1. Ажлын алба нь эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээчийн сонгон шалгаруулалтыг шаардлагатай мэргэшлийн чиглэлээр нээлттэй зарлаж явуулна.

2.2. Шинжээчийн сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг сонгон шалгаруулалт явагдахаас 21 хоногийн өмнө олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлан мэдээлнэ.

2.3. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээчид нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна.

2.3.1. Монгол Улсын иргэн байх;

2.3.2. Насны дээд хязгаар 65 нас;

2.3.3. Анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тоног төхөөрөмж болон бусад шаардлагатай чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн;

2.3.4. Мэргэшлийн зэрэг эсхүл эрдмийн цолтой;

2.3.5. Эрүүл мэндийн байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс тасаг, нэгжийн эрхлэгч болон түүнээс дээш удирдах албан тушаал эрхэлсэн ба эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;

2.3.6. Эрүүл мэндийн удирдлага, тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын чиглэлээр гадаад, дотоодод урт, богино хугацааны сургалтад хамрагдаж байсан, судалгаа, шинжилгээний ажил хийж байсан туршлагатай байх;

- 2.3.7. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах чадвартай байх;
- 2.3.8. Бичиг баримт боловсруулах, тайлагнах ур чадвартай байх;
- 2.3.9. Компьютерийн өргөн хэрэглээний програм болон цахим орчинд ажиллах чадвартай байх;
- 2.3.10. Эрүүл мэндийн байгууллагад дарга/захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн даргын албан тушаал эрхэлдэггүй байх;
- 2.3.11. Ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй;
- 2.3.12. Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй;
- 2.3.13. Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, эмнэл зүйн шинжээчээр давхар ажиллаагүй байх;

2.4. Шинжээчид нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ:

- 2.4.1. Хувийн өргөдөл;
- 2.4.2. Төрийн албан хаагчийн анкет;
- 2.4.3. Иргэний үнэмлэхний хуулбар;
- 2.4.4. Дээд боловсролын диплом, мэргэшлийн үнэмлэх, удирдлагын сургалтын гэрчилгээ, судалгаа, шинжилгээний ажил, эрдмийн цол болон мэргэшлийн зэргийн нотлох баримтын хуулбар;
- 2.4.5. Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ батлагдсан маягтаар илэрхийлсэн мэдэгдэл (Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан маягт);
- 2.4.6. 3x4 хэмжээтэй 2 хувь зураг;
- 2.4.7. Ёс зүйн салбар хорооны тодорхойлолт;
- 2.4.8. Эрүүл мэндийн байгууллагад ажилладаг нэр дэвшигч нь тухайн харъяалах байгууллагын удирдлагаас шинжээчээр ажиллахыг зөвшөөрсөн болон ур чадварыг тодорхойлсон албан бичиг.

2.5. Ажлын алба нь нэр дэвшигчийн баримт бичгийн бүрдлийг хянаж, хүлээн авч, бүртгэнэ.

2.6. Шинжээчээр нэр дэвшигч нь энэхүү журмын 2.3; 2.4-т заасан шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд ажлын албанаас ярилцлага, ур чадварын үнэлгээг зохион байгуулна.

2.7. Ажлын алба нь шинжээчид нэр дэвшигчтэй ярилцлага, ур чадварын үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийн саналыг боловсруулж, магадлан итгэмжлэх зөвлөлийн хуралд тухай бүр танилцуулж шийдвэрлүүлнэ.

2.8. Шинжээчийн ур чадварын үнэлгээг асуудал шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх, удирдан зохион байгуулах, багаар ажиллах, илтгэх, чадвар, компьютерийн хэрэглээний програм болон цахим орчинд ажиллах чадвараар үнэлнэ.

2.9. Ур чадварын үнэлгээний дүнг ажлын хэсгийн гишүүдийн гарын үсэг бүхий тэмдэглэл, дүнгийн хуудсаар баталгаажна.

2.10. Баримт бичгийн бүрдэл болон ур чадварын үнэлгээний дүнг магадлан итгэмжлэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

2.11. Магадлан итгэмжлэх зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн сонгон шалгаруулсан шинжээчийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталгаажуулна.

2.12. Шинжээчийн магадлан итгэмжлэлийн үнэлгээ хийх хугацаанд үндсэн ажлаас чөлөөлөх үүргийг харъяалах байгууллагын удирдлага хүлээнэ.

Гурав. Ажлын албаны чиг үүрэг

3.1. Ажлын алба нь шинжээчийг нэр дэвшүүлсэн байгууллага, шинжээчтэй гэрээ байгуулж, үнэмлэх олгоно.

3.2. Шинжээчийн гэрээний загварыг ажлын алба боловсруулж, батлуулна.

3.3. Батлагдсан удирдамж, хуваарийн дагуу шинжээчийг багаар томилон ажиллуулах ба шинжээчид урьдчилан мэдэгдэнэ.

3.4. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн хурлаар тухайн байгууллагад хийгдсэн үнэлгээний дүгнэлтийг хэлэлцүүлэхэд шинжээчийн багийг оролцуулна.

3.5. Шинжээчийн эрүүл мэндийн байгууллагад үнэлгээ хийсэн хугацаа, ажлын үр дүнг нь харгалзан холбогдох журамд заасны дагуу ажлын хөлс олгоно.

3.6. Шинжээчийг ажлын байранд ажиллах нөхцлийг бүрдүүлэн, аюулгүй байдлыг хангаж, гэнэтийн ослын улмаас амь нас эрсдэх тохиолдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай зөвшөөрөл бүхий даатгалын компанитай хамтран амь насны даатгалд хамруулна.

3.7. Шинжээчийг чадавхижуулах сургалтыг үе шаттай тасралтгүй зохион байгуулж, үр чадварыг сайжруулна.

3.8. Шинжээчийн холбогдох мэдээллийг агуулсан мэдээний сан үүсгэж, тогтмол баяжилт хийнэ.

Дөрөв. Шинжээчийн чиг, үүрэг

4.1. Магадлан итгэмжлэлийн шинжээч нь холбогдох хууль, стандарт, тушаал, журмын хүрээнд эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, технологи, гүйцэтгэлд хөндлөнгийн хараат бус үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.

4.2. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан Эрүүл мэндийн байгууллагад батлагдсан хуваарийн дагуу ажиллана.

4.3. Магадлан итгэмжлэлд хамрагдах байгууллагаас ирүүлсэн баримт бичигтэй урьдчилан танилцаж, мэдээлэл авна.

4.4. Шинжээч нь багаар ажиллаж, магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу бодит нөхцөл байдлыг үнэн, зөв үнэлж, дүгнэлт гаргахад багийн гишүүд тэгш эрхтэй оролцоно.

4.5. Үнэлгээний явцад шаардлагатай зарим нэмэлт мэдээлэл, материалтай танилцаж болно.

4.6. Багийн ахлагч нь багийн гишүүдийг чиглүүлж, ажил, үүргийг хуваарилан үнэлгээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

4.7. Багийн гишүүд үнэлгээ, дүгнэлттэй холбогдох баримт бичгийг боловсруулж, магадлан итгэмжлэх журамд заасан хугацаанд багийн ахлагчид хүлээлгэн өгнө.

4.8. Багийн ахлагч гишүүдийн боловсруулсан баримт бичгийг хянаж, нэгтгэн, баталгаажуулж, журамд заасан хугацаанд ажлын албанд хүлээлгэн өгнө.

4.9. Үнэлгээний нэгдсэн дүнг багийн бүх гишүүд хүлээн зөвшөөрсөн байна.

4.10. Шинжээчийн баг нь ажлын албаны заавар, зөвлөмжийн дагуу ажиллаж, үнэлгээний дүгнэлтийг зөвлөлийн хуралд хамтран танилцуулна.

4.11. Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгийг судлах, тусламж үйлчилгээний шинэ технологи, арга аргачлалын талаар мэдээлэл олж авах, тасралтгүй суралцаж, өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ.

4.12. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

4.13. Зөвлөл, ажлын албанаас өгсөн заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх, зохион байгуулагдах сургалт, хэлэлцүүлэг, уулзалт болон бусад үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, санал хүсэлтээ илэрхийлнэ.

4.14. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ажил үүргийн хүрээнд олж авсан мэдээллийн нууцлалыг хадгалж, хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, бусдад задруулах, ашиглуулахыг хориглох, зөвхөн магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаанд ашиглах.

4.15. Байгууллагад үнэлгээ хийх тохиолдол бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлж, зөрчил үүссэн тухай бүр татгалзаж, ажлын албанд мэдэгдэнэ.

Тав. Шинжээчийн гэрээг дүгнэх, чөлөөлөх

5.1. Шинжээчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ ажлын алба, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллага, шинжээчдийн оролцоог хангаж, хагас жилд зохион байгуулна.

5.2. Гэрээний биелэлтийг хагас жил тутамд дүгнэж, гэрээний хугацааг сунгах эсэхийг шийдвэрлэнэ.

5.3. Шинжээчийг дараах тохиолдолд чөлөөлж, шинжээчтэй хийсэн гэрээг цуцална.

5.3.1. Өөрийн хүсэлтийг үндэслэн;

5.3.2. Мэргэжлийн алдаа болон ёс зүйн зөрчил гаргасан нь холбогдох байгууллагаар тогтоогдсон;

5.3.3. Авлига, ашиг сонирхлын зөрчил гарсан нь нотлогдсон;

5.3.4. Байгууллага, хувь хүний нууцыг задруулсан нь тогтоогдсон;

5.3.5. Хуурамч дүгнэлт гаргасан;

5.3.6. Хараат бус байдлыг хангаж ажиллаагүй, хөндлөнгийн нөлөөлөлд автсан нь тогтоогдсон;

5.3.7. Гэрээний үнэлгээгээр 2 ба түүнээс дээш удаа хангалтгүй дүгнэгдсэн;

5.3.8. Гэрээний заалт зөрчсөн;

5.3.9. Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон, эсхүл авилгын болон албан тушаалын хэрэгт буруутгагдаж хууль зүйн хариуцлага хүлээсэн бол.

Зургаа. Хариуцлага

6.1. Шинжээчтэй хийсэн гэрээний үнэлгээгээр “Хангалтгүй” үнэлэгдсэн, энэ журмын 5.3.7-д заасны дагуу гэрээ цуцлагдсан тохиолдолд 3 жилийн хугацаанд дахин сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.

6.2.Шинжээч сонгон шалгаруулах, томилон ажиллуулах, чөлөөлөхтэй холбоотой энэхүү журмыг зөрчсөн аж ахуйн нэгж байгууллага, эрүүл мэндийн байгууллага, эрх бүхий холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

11 Эрүүл мэндийн сайдын 2023 оны
.....дүгээр сарын 22 -ны өдрийн 1/412
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанарын тасралтгүй хөгжил, ахиц дэвшилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд мөрдөнө.
- 1.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад чиглэнэ.
- 1.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээг магадлан итгэмжлэгдсэн хугацаанаас хамаарч 1-ээс доошгүй удаа хийнэ.
- 1.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээг ажлын алба, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, төрийн бус байгууллага хамтран гүйцэтгэж болно.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, зохион байгуулалт

- 2.1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад хийх хяналт-шинжилгээ үнэлгээний нэгдсэн удирдамж, төлөвлөгөө, хуваарийг батлуулж хэрэгжүүлнэ.
- 2.2. Магадлан итгэмжлэгдсэн байгууллага бүр итгэмжлэгдсэн хугацаанаас хамаарч хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдана.
- 2.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээг батлагдсан үнэлгээний хуудсаар хийх ба тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, тусламж, үйлчилгээнд гарсан ахиц дэвшил, магадлан итгэмжлэлийн шинжээчийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн үйл ажиллагааг хамруулна.
- 2.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан байгууллагад дүгнэлт, зөвлөмж хүргэгдэх ба зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.
- 2.5. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн байгууллагад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ажлын албанд, ажлын алба үнэлгээний тайланг нэгтгэн магадлан итгэмжлэлийн зөвлөлд жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайлагнана.
- 2.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хангалтгүй дүгнэгдсэн эрүүл мэндийн байгууллагад 3 сарын хугацаатай ажил сайжруулах үүрэг даалгавар өгч, ажлын алба, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар биелэлтэд хяналт тавьж ажиллана.
- 2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хангалтгүй дүгнэгдсэн эрүүл мэндийн байгууллага зөвлөмжийн биелэлтийг хангаагүй тохиолдолд ажлын алба Магадлан итгэмжлэлийн зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлнэ.
- 2.8. Эрүүл мэндийн байгууллага, түүний удирдлага, албан тушаалтан нь хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

2.9. Эрүүл мэндийн байгууллагын удирдлага нь нь тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулсан сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, гарсан алдаа, дутагдлыг засч, залруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

3.1. Хяналт шинжилгээ үнэлгээний хүрээнд шалгуур үзүүлэлтийн дагуу нотлох баримт бичигтэй танилцах, ярилцах, ажиглалт, газар дээр ажиллах зэрэг аргуудыг ашиглана.

3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт нь үндсэн ба тусгай гэсэн 2 хэсгээс бүрдэх ба үндсэн шалгуурыг 14, тусгай шалгуурыг 18 үзүүлэлтээр үнэлнэ.

3.3. Шалгуур үзүүлэлт бүрийг оноогоор дүгнэх ба шалгуур үзүүлэлтэд заагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн, зохион байгуулж байгаа үйл ажиллагаа тогтмолжиж хэвшсэн бол 2 оноо, зарим үйл ажиллагаа зохион байгуулалтад орсон, тогтмолжиж хэвшээгүй бол 1 оноо, үйл ажиллагаа зохион байгуулалтад ороогүй, хэрэгждэггүй бол 0 оноо өгнө.

3.4. Үндсэн шалгуур үзүүлэлтийн авбал зохих оноо 28, тусгай шалгуур үзүүлэлтийн авбал зохих оноо 36 байна. Шалгуур үзүүлэлт тус бүрийн авбал зохих оноог бүрэн авсан бол 100 хувь хангасан гэж үзнэ.

3.5. Үндсэн болон тусгай шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээгээр 80 ба түүнээс дээш хувиар үнэлэгдсэн бол хангалттай, 70-79 хувиар үнэлэгдсэн бол сайжруулах шаардлагатай, 69 ба түүнээс доош үнэлэгдсэн бол хангалтгүй гэж дүгнэнэ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Үнэлгээний загвар хүснэгт

Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тоо	Авбал зохих оноо	Авсан оноо	Хувь
Үндсэн шалгуур үзүүлэлт	14	28 оноо буюу 100%		
Тусгай шалгуур үзүүлэлт	18	36 оноо буюу 100%		

3.6. Үйлчлүүлэгчээс төрийн захиргааны аль нэг байгууллага (ЭМЯ, Салбарын хяналтын газар, Ёс зүйн хороо, аймаг, нийслэлийн ЭМГ, орон нутгийн засаг захиргааны байгууллага гэх мэт)-д ёс зүй, харилцаа, хариуцлагатай холбоотой гомдол гарсан бол үнэлгээний нийт онооноос 5 оноог хасна.

Дөрөв. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний хуудас

1. Байгууллагын мэдээлэл:

№	Асуумж	Тэмдэглэл
1	Байгууллагын нэр (Тусгай зөвшөөрөлд бичигдсэнээр)	
2	Тусламж, үйлчилгээний чиглэл, төрөл (Тусгай зөвшөөрөлд бичигдсэнээр)	
3	Одоо үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний чиглэл, төрөл	
4	Байгууллагын албан ёсны хаяг (Тусгай зөвшөөрөлд бичигдсэнээр)	
5	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	
6	Батлагдсан орны тоо	
7	Магадлан итгэмжлэгдсэн удаа (оноор)	
8	Хүчинтэй байгаа магадлан итгэмжлэл	

	<ul style="list-style-type: none"> - Батламжийн дугаар: - Магадлан итгэмжлэгдсэн хугацаа: - Эхлэх он, сар, өдөр: - Дуусах он, сар, өдөр: 	
--	--	--

2. Үндсэн болон тусгай шалгуур үзүүлэлтийг оноогоор үнэлэх:

Оноо	Үзүүлэлт
2	Тогтолцоо бүрдсэн, зохион байгуулж байгаа үйл ажиллагаа тогтмолжиж хэвшсэн.
1	Зарим үйл ажиллагаа зохион байгуулалтад орсон ч тогтмолжиж хэвшээгүй.
0	Үйл ажиллагаа зохион байгуулалтад ороогүй, хэрэгждэггүй.

3. Үндсэн шалгуур үзүүлэлт, оноогоор үнэлэх

№	Шалгуур үзүүлэлт	Үр дүнг хэмжих үзүүлэлт/Нотолгоо	Оноо
1.	Тусгай зөвшөөрөлд заагдсан тусламж, үйлчилгээг бүрэн үзүүлдэг байх	<ul style="list-style-type: none"> - Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ - Бүтэц, орон тоо баталсан тушаал - Тойрон үзлэг 	
2.	Тусгай зөвшөөрөлд заагдсан тусламж, үйлчилгээний чиглэлийн дагуу холбогдох бүтэц, үйл ажиллагааны стандартыг үндэслэн тасаг, нэгжийг зохион байгуулсан байх	<ul style="list-style-type: none"> - MNS стандарт - Бүтэц, зохион байгуулалт баталсан тушаал - Ор баталсан тушаал - Тойрон үзлэг 	
3.	Тусламж, үйлчилгээний чиглэл бүрээр хүний нөөцөөр бүрэн хангагдсан байх	<ul style="list-style-type: none"> - Бүтэц, орон тоо баталсан тушаал - Хүний нөөцийн судалгаа - MNS стандарттай харьцуулсан хувь - Нийгмийн даатгал төлөлтийн тайлан <ul style="list-style-type: none"> • 90-100% - 2 • 80-89% - 1 • 79%-аас доош - 0 	
4.	Тусламж, үйлчилгээний чиглэл бүрээр хүний нөөцөөр бүрэн хангагдсан байх	Тусламж үйлчилгээний сүүлийн 2 жилийн статистик үзүүлэлт	
5.	Стандартын шаардлага хангасан байртай, урсгал зөв, эрүүл ахуйн шаардлага хангасан байх	<ul style="list-style-type: none"> - Ажлын байрны дүгнэлт, гэрээ - Тасаг нэгжийн зохион байгуулалт - Өрөө, тасалгааны хүрэлцээ - Үйлчлүүлэгчийн ээлтэй орчин бүрдсэн эсэх 	
6.	Байгууллагын стратеги төлөвлөгөөтэй, хэрэгжүүлдэг байх	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан стратеги төлөвлөгөө - Тайлан - Бусад төлөвлөгөөтэй уялдуулсан байх 	
7.	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөртэй, хэрэгжүүлдэг байх	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр - Тайлан 	
8.	Ажилтнуудын ажлын гүйцэтгэлд үнэлгээ хийдэг, гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоотой байх	<ul style="list-style-type: none"> - Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт - Тушаал шийдвэр, УЗ-ийн хурлаар хэлэлцсэн шийдвэр - Урамшуулалд олгосон зардлын хэмжээ 	
9.	Хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг тогтмол сайжруулан, мэргэшүүлэх чиглэлээр ажилладаг байх	<ul style="list-style-type: none"> - Сургалтын орчин - Магадлан итгэмжлэлийн хугацаанд мэргэшил эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтний тоо 	

		<ul style="list-style-type: none"> - Дотоод сургалтын төлөвлөгөө, хэрэгжилт - Боловсролын болон мэргэшлийн зэрэг хамгаалсан эмнэлгийн мэргэжилтний тоо - Хүний нөөцийг чадавхижуулахад зарцуулсан зардлын хэмжээ 	
10.	Хүний нөөцийн тогтвор суурьшлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулдаг байх	<ul style="list-style-type: none"> - Хүний нөөцийн тогтвор суурьшлын хувь - Нийгмийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ 	
11.	Багаж тоног төхөөрөмжийн хангалтыг жил бүр сайжруулж ажилладаг байх	<ul style="list-style-type: none"> - Тоног төхөөрөмжийг хангалтыг сайжруулах төлөвлөгөө, биелэлт - Тоног төхөөрөмжийн мэдээний сан - MNS стандартын дагуу гаргасан жагсаалт - Шинэчилсэн тоног төхөөрөмжийн тоо, бүртгэл - Хангалтын хувь 	
12.	Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн баталгаажилт, шалгалт, тохируулгад жил бүр хамрагддаг, засвар үйлчилгээ тогтмолжсон байх	<ul style="list-style-type: none"> - Баталгаажилт, шалгалт тохируулгад хамруулах төлөвлөлт, хамрагдсан тоног төхөөрөмжийн тоо, дүгнэлт - Засвар, үйлчилгээний бүртгэл 	
13.	Шинжээчийн зөвлөмжийн биелэлтийг хангаж ажилласан байх	<ul style="list-style-type: none"> - Зөвлөмж хүлээн авсан байх - ЭМТҮЧАБ-ын төлөвлөгөөнд тусгасан байдал - Биелэлтэд хяналт тавьж ажилладаг байдал <ul style="list-style-type: none"> • 80%-аас дээш - 2 • 70-79% - 1 • 69%-иас доош - 0 	
14.	Дараагийн магадлан итгэмжлэлд хүсэлт гаргахаас 12-24 сарын өмнөөс бэлтгэл ажлыг эхлүүлсэн байх	<p>Хурлын тэмдэглэл</p> <ul style="list-style-type: none"> - Бэлтгэл ажлын төлөвлөгөө, хэрэгжилт 	

4. Тусгай шалгуур үзүүлэлт, оноогоор үнэлэх

№	Шалгуур үзүүлэлт	Үр дүнг хэмжих үзүүлэлт/Нотолгоо	Оноо
1.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөтэй, хэрэгжүүлж ажилладаг байх	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан төлөвлөгөө - Хэрэгжилтийн тайланг жил бүр гарган, хэлэлцүүлсэн 	
2.	Чанарын алба/багийг бүрэн орон тоогоор ажиллуулдаг байх	<ul style="list-style-type: none"> - Алба/баг томилсон тушаал - Албан тушаалын тодорхойлолт - Чанарын багийн төлөвлөгөө, тайлан 	
3.	Тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ, түгээн дэлгэрүүлсэн сайн туршлага	<ul style="list-style-type: none"> - Тусламж, үйлчилгээний чанар сайжруулах чиглэлээр хийсэн ажлын тайлан - Хэлэлцүүлсэн тайлан - Нэвтрүүлсэн сайн туршлага 	

4. Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр эрүүл мэндийн ажилтанд жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байх, ахиц дэвшил гарсан байх	<ul style="list-style-type: none"> - Боловсруулж, баталсан шалгуур үзүүлэлтийн төрөл, тоо - Дүн шинжилгээ, тайлан - Хэлэлцүүлсэн байдал - Сайжруулах чиглэлээр авсан арга хэмжээ, хяналт 	
5. Тусламж, үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байх	<ul style="list-style-type: none"> - Нэвтрүүлсэн шинэ технологи, тусламж, үйлчилгээний нэр төрөл 	
6. Эмнэл зүйн стандарт, заавар, удирдамжийн хэрэгжилтийг хангаж ажилладаг байх	<ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн хэмжээнд мөрдөн ажиллах жагсаалттай байх - Хяналтын хуудсаар үнэлгээ хийсэн байх - Үнэлгээний дүгнэлт - UpToDate хэрэглэдэг эмнэлгийн мэргэжилтний тоо нэмэгдсэн байх 	
7. Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чиглэлээр дотоод хяналт, үнэлгээг тогтмол хийдэг байх	<ul style="list-style-type: none"> - Хяналт үнэлгээ хийх хуваарь - Тайлан - Хяналт, авсан арга хэмжээ 	
8. Байгууллагын эрсдэлийн үнэлгээг жил бүр хийдэг, эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авдаг байх	<ul style="list-style-type: none"> - Эрсдэлийн үнэлгээ хийсэн тайлан - Эрсдэл бууруулах төлөвлөгөө - Авсан арга хэмжээний тайлан 	
9. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой гарсан тохиолдлыг бүрэн бүртгэж, мэдээлдэг тогтолцоог бүрдүүлсэн байх	<ul style="list-style-type: none"> - Eburtgel.moh.gov.mn-ийг ашигладаг - Бүртгэсэн тохиолдол, эрсдэлийн тоо - Хяналт, авсан арга хэмжээ 	
10. Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулж, тусламж үзүүлдэг тогтолцоо бүрдсэн байх	<ul style="list-style-type: none"> - Зохицуулсан журам - Журмын хэрэгжилт - Үнэлгээний хуудас, хийсэн үнэлгээ - Хяналт, авсан арга хэмжээ 	
11. Унах эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авч ажилладаг байх	<ul style="list-style-type: none"> - Зохицуулсан журам, хэрэгжилт - Унахаас сэргийлсэн орчин - Үнэлгээний хуудас, хийсэн үнэлгээ - Хяналт, авсан арга хэмжээ 	
12. Мэс заслын аюулгүй байдлыг хангаж ажилладаг байх	<ul style="list-style-type: none"> - Зохицуулсан журам - Хяналтын хуудас (өмнө, дараах) - Мэс засал, мэс ажилбар хийхийн өмнө Time out-ын хуудсыг бүрэн хөтөлсөн - Халдварын тандалтын хуудас хөтөлсөн 	
13. Эмийн аюулгүй байдлыг хангаж ажилладаг байх	<ul style="list-style-type: none"> - Зохицуулсан журам, хэрэгжилт - Эмийн жагсаалт - Сургалт - Хяналт, авсан арга хэмжээ 	
14. Эмнэл зүйн зохистой, үр дүнтэй харилцаа бүрдүүлсэн байх	<ul style="list-style-type: none"> - Өвчтөн хүлээлцэх, шилжүүлэх үйл ажиллагааг зохицуулсан журам - Хяналтын хуудас - Тайлан, бүртгэл 	

<p>15. Эмнэлгийн үйлчилгээтэй халдварын бууруулах тогтмол авдаг байх</p>	<p>тусламж, холбоотой эрсдэлийг арга хэмжээг</p>	<ul style="list-style-type: none"> - Хариуцсан алба/баг, ажилтан - ХСХ-ын төлөвлөгөө - Хяналт, үнэлгээ, тандалт хийх хуваарь - Тайлан, дүгнэлт - Сургалт
<p>16. Яаралтай байдлыг хангаж байх</p>	<p>тусламжийн бэлэн ажилладаг</p>	<ul style="list-style-type: none"> - Зохицуулсан журам, хэрэгжилт - Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдал - Сургалт - Хяналт, авсан арга хэмжээ
<p>17. Үйлчлүүлэгч болон хэрэглэгчийн авч, тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авч ажилладаг байх</p>	<p>болон ажилтнаас үнэлгээ тогтмол авч, тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авч ажилладаг байх</p>	<ul style="list-style-type: none"> - Сэтгэл ханамжийн судалгаа, тайлан - Түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ - Эргэн мэдээлсэн байдал
<p>18. Үйлчлүүлэгч болон ирсэн санал, хүсэлт, гомдлыг бүртгэдэг байх, түүний мөрөөр ажил зохион байгуулдаг, эргэн мэдээлдэг тогтолцоо бүрдсэн байх</p>	<p>болон ажилтнаас ирсэн санал, хүсэлт, гомдлыг бүртгэдэг байх, түүний мөрөөр ажил зохион байгуулдаг, эргэн мэдээлдэг тогтолцоо бүрдсэн байх</p>	<ul style="list-style-type: none"> - Бүртгэсэн санал, хүсэлт, гомдол - Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ - Эргэн мэдээлсэн байдал

---000---